



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэлд:

"IX.ХЭЛЭЛЦСЭН нь:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Сонгинохайрхан дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилгыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвд албан ажлын зориулалтаар ашиглуулахаар балансаас балансад шилжүүлэх тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2018 оны 1/3645 дугаар албан бичгээр өөрийн харьяа Сонгинохайрхан дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга байгууламжийг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвд албан ажлын зориулалтаар ашиглуулахаар балансаас балансад шилжүүлж өгөхийг хүссэн байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Сонгинохайрхан дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 299,000,000.00 (хоёр зуун ерэн есөн сая) төгрөгийн балансын үнэ, 49,833,334.00 (дөчин есөн сая найман зуун гучин гурван мянга гурван зуун гучин дөрвөн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2008 онд ашиглалтад орсон Сонгинохайрхан дүүргийн 15 дугаар хороо, 1-р хороолол, Өнөр хорооллын гудамжинд байрлах барилгыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвд балансаас балансад шилжүүлэх саналыг дэмжиж, Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

080299